

22 April 2021

**Report to Bank of Mongolia by Independent Director – Niraj Vedwa**

I, Niraj Vedwa, Independent Director on Board of Xacbank, wish to state that I have performed my Duties in accordance with the Banking Laws as Defined by Bank of Mongolia and the Board Charter of Xacbank.

I have been Member of Board Audit and Risk Management Committees and participated in all Monthly Update Calls / Quarterly Board Meetings / Annual Board Meeting an AGM. I also participated in all the BRMC and Audit Committee meetings. Due to Covid and travel restrictions, all Board meetings were held over Video Conference. I also participated in all IT Steering committee meetings held over the course of last 12 months.

Xacbank maintained strong Corporate Governance and maintained its reputation as one of the Best managed Banks in Mongolia. As Independent Director, I support the “Good Corporate Governance” throughout the year. Through the various meetings, I was involved in Discussions, Review and Implementation of Bank Strategy / IT Strategy / Digital Transformation Strategy / Org Structure / Risk Management Policy / Annual Budgets / Business plans. Was also involved in review and setting up Internal Audit Control Systems and Corporate Governance policies. I also participated in IT Steering committee meetings.


I confirm that actions of Bank Management and Board has complied with laws and regulations. Audited results for the quarters have been reviewed by me in the Audit committee / Board Meeting and I confirm that the financial results are a correct representation of performance.

During these tough Covid times, Management formulated a new strategy to make the Balance sheet healthier. Annual & Quarterly Budgets, Business Plans and Key Operational metrics were discussed and approved / finalized. Bank has made significant progress despite the most challenging times.

In line with Bank’s objective to become “Digital”, various Digital Transformation initiatives have been taken. A new state of art “Digital Omnichannel Platform” has just gone live. This will bring about Superior Customer Experience and Instant Onboarding. Xacbank has embarked on replacement of legacy Core banking system with a new Modern Core Banking System. This will give Bank a “Strong Digital Edge” and help in reducing cost / enhancing customer experience. We expect this Digital Transformation to be completed in this financial year.

Very good progress has been made on both Retail Banking & Corporate Banking which will position bank well in future and when we get over this difficult Covid-19 phase. Xacbank delivered very strong results in the financial year led by Chairman / Board and Management. Our Chairman is deeply engaged in giving Strategic Vision and Guidance.

With a strong Board and Management team, I am confident that Xacbank will continue to achieve budgets and key metrics and stand out as a Leader in Corporate Governance.



Niraj Vedwa

Independent Director

2021 оны 4-р сарын 22

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Нираж Вэдва-гийн Монголбанкинд хүргүүлэх тайлан**

Нираж Вэдва, миний бие ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ) хараат бус гишүүний үүрэгт ажлаа Монгол Улсын Банкны тухай хууль болон ХасБанкны ТУЗ-ийн дүрэмд заасан ёсны дагуу бүрэн биелүүлсэн гэдгийг баталж байна.

Миний бие ТУЗ-ийн Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж, бүх ээлжит хурал болон цаг тухайн мэдээллийн чанартай хурлуудад алгасалгүй оролцсон бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцов. Ковидын цар тахал болон хөдөлгөөний хязгаарлалтын улмаас ТУЗ-ийн хурал онлайн хэлбэрээр явагдсан болно. Мөн, сүүлийн 12 сард зохион байгуулагдсан Мэдээллийн технологийн удирдлагын хорооны хуралд оролцжээ.

ХасБанк нь компанийн засаглалын хувьд тогтвортой бөгөөд Монголдоо шилдэг менежменттэй банк хэмээн үнэлэгддэг. Хараат бус гишүүний хувьд “компанийн сайн засаглал”-ыг дэмжин ажиллаж ирлээ. Олон удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцохын зэрэгцээ Банкны стратеги/байгууллагын бүтэц зохион байгуулалт/эрсдэлийн удирдлагын бодлого/жилийн төсөв/бизнес төлөвлөгөө зэргийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр ажиллав. Мөн Дотоод аудитын хяналтын тогтолцоо болон Компанийн засаглалын бодлогыг хэлэлцэх, батлах ажлуудад оролцож, санал бодлоо илэрхийлж ажиллалаа. Мөн, Мэдээллийн технологийн хорооны хуралд оролцсон болно.

Банкны менежмент болон ТУЗ-ийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явагдсаныг үүгээр баталж байна. Аудитлагдсан тайланг Аудитын хороо/ТУЗ-ийн хурлын үеэр миний бие сайтар нягталж үзсэн бөгөөд санхүүгийн тайлан нь зохих ёсоор гарсныг баталж байна.

Ковидын цар тахлын үед менежментийн баг шинэ стратеги боловсруулж үйл ажиллагааг тогтворжуулж байна. Жилийн болон улирлын төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг зохих журмаар хэлэлцэж эцэслэн баталлаа. Банк хүнд хэцүү үеийг тодорхой ахицтайгаар даван туулж байна.

“Цахим” болох банкны зорилтын дагуу цахим банк болон мэдээллийн технологийн талаар олон ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүний тод жишээ нь одоо хэрэгжүүлж байгаа “Digital Omnichannel Platform”-ийн сүүлийн үе шат юм. Уг платформын ачаар харилцагчдад шинэ төвшинд үйлчлэх боломжтой. ХасБанк банкны үндсэн системийг сайжруулахаар ажиллаж байна. Ингэснээр, үйл ажиллагаатай холбоотой зардлыг багасгаж ажлын бүтээмжийг дээшлүүлж “Дижитал” болох боломжтой болно. Цахим шилжилтийн ажлыг бид энэ оны санхүүгийн жилд дуусгахаар ажиллаж байгаа билээ.

Иргэдийн болон байгууллагын банкны хувьд ч ахиц гарсан, үүний ачаар Ковид-19-ийн үед тулгарч байгаа хүнд хэцүү нөхцөл байдлыг даван туулахаар байна. ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагын зөв удирдлага дор санхүүгийн жилийг амжилттай даван туулжээ. Банкны ТУЗ-ийн дарга Стратегийн алсын хараа, зорилгыг тодорхойлоход ихэд хичээнгүйлэн ажилласан болно.

ТУЗ болон удирдлагын багийн хүчин чармайлтын үр дүнд ХасБанк цаашид улам амжилттай ажиллаж, зорилтот үзүүлэлтүүдийг хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

/гарын үсэг/

Нираж Вэдва